

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Ц.Оюунтунгалаг\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** олон нийтийн радио, нэвтрүүлгийн хүртээмж, хараат бус байдал нийгмийн үнэт зүйл, өргөн нэвтрүүлэг, монополь эрх, нэвтрүүлгийн бодлого.

Олон нийтийн радио дэлхий дахинаа үүсч хөгжсөнөөс хойш 90 гаруй жил өнгөрч байна. “Public broadcasting” буюу “Олон нийтийн радио, телевиз” гэдэг нэр томъёо үгийн гарлын хувьд анх 1922 онд тэмдэглэгдэж, төсвийн дэмжлэгтэй, арилжааны бус, бие даасан байгууллага гэсэн утгаар хэлний тольд тайлбарлажээ. Олон нийтийн радио бол олон нийтийг соён гэгээрүүлэгч, мэдлэг түгээгч, ардчиллын хөгжлийг гүнзгийрүүлэгч нийгэмд онцгой үүрэгтэй субъект мөн. Товчхондоо “олон нийтэл үйлчлэх” (public served) гэдэг нь тэдний ардчилсан эрхээ эдлэх, ёс суртахууны үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлж, боломжийг бүрдүүлэхийг хэлнэ. Монгол Улсын Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 3.1-д “Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа

явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн”<sup>1</sup> гэж тодорхойлжээ.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд хэд хэдэн онцгой шинж чанартай бөгөөд тэдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаанд үндэслэсэн байдаг. Энэ утгаараа олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн гол зорилго нь тухайн улсын хүн амын олон төрлийн болон өргөн хэрэгцээг тусгасан мэдээлэл, цэнгээнт ба боловсрол танин мэдэхүйн чанартай нэвтрүүлгээр хангахад оршино. Олон нийтийн радио хэдий чинээ сонгодог утгаараа хөгжинө төдий чинээ нийгмийн үнэт зүйлийг бүрдүүлэгч болж чадна. Олон нийтийн радио нь захиалгат сэтгүүл зүй болон хэвлэл мэдээллийн төвлөрлийн эсрэг баталгаа гэж үзвэл олон нийтийн радиогийн үнэ цэнэ улам тодорхой болох юм.

Олон нийтийн радио нь тухайн улсынхаа ардчиллын хөгжлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэгч, нийгмийн үнэт зүйлийг бүрдүүлэгч, онцгой чиг үүрэг бүхий субъект юм. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 2005 оны 1 дүгээр сарын 27-нд УИХ-аар баталж, тухайн оныхоо 4 сарын 1-нд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлжээ. Энэ

хуулийн дагуу Засгийн газрын мэдэлд байсан өмч хөрөнгө нь нийтийн өмч болон олон нийтийн радиогийн өмчлөлд шилжжээ. Мөн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хуульд нийцүүлэн бүтцийн өөрчлөлт хийх болон программын шинэчлэл хийх ажлыг эхлүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 241 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Радио, телевизийн хэрэг эрхлэх газар”-ыг татан буулгах шийдвэр гарч, Үндэсний олон ний-

тийн радио, телевиз болгон зохион байгуулснаар

Монголын үндэсний олон нийтийн радиогийн хөгжлийн шинэ хуудас нээгдсэн юм. Энэхүү өөрчлөлтөөр Монголын үндэсний олон нийтийн радио нь төр засгийн мэдлээс гарч, олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд болсон байна. Олон нийтийн радио гагцхүү хуулийн дагуу байгуулж, хуулиар татан буулгах эрх зүйн хамгаалалт хийж өгсөн нь улстөрчдийн дур зоргоос ангид байх таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Ингэснээрээ МҮОНР нь цоо шинэ нийгмийн институт болон хөгжих эхлэл тавигдсан ба үйл ажиллагаагаа Олон нийтийн радио телевизийн тухай хууль болон үндэсний бусад хууль тогтоомжид нийцүүлэхээс гадна олон улсын олон нийтийн радиогийн нийтлэг жишиг

зарчмуудыг баримтлан ажиллах шинэ шаардлага гарч ирэв.

МҮОНР-гийн хувьд ОНРТВ-ийн тухай хуулийн 4.1-д “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах, иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална”<sup>2</sup> гэж заажээ.

«

*МҮОНР-гийн шилжилтийн үед Шведийн радиогийн төслүүд онцгой дэмжлэг болж, ОНР-гийн хамт олонд оюуны бодитой хөрөнгө оруулалт болсон юм. МҮОНР-гийн статусын өөрчлөлт нь харьцангуй амжилттай хийгдсэн ба олон улсын олон нийтийн радиогийн загварт нэлээд дөхсөн ололтуудыг бий болгож чадсан*

»

“МҮОНР

болон “Хурд” мэдээний агентлагт гарсан ахиц дэвшлийн хувьд бие даасан хараат бус статустай болж, хуучин тогтолцооны үеэс улбаатай үзэл суртлын зэвсэг байх явдлаас ангижирсан нь томоохон үсрэлт болсон. Өнөөдөр Монголын Үндэсний радио олон нийтийн

өргөн нэвтрүүлгийн байгууллага болон төлөвшихөөр эргэлт буцалтгүй тэмүүлж, шилжилтийн үеийг амжилттай даван туулж байна. Энд бид бүхэн бие даасан хараат бус, аль нэг талыг дулдуйдахгүй, олон нийтийн итгэл хүлээсэн бөгөөд мэргэжлийн байх зарчмыг авч үзэж байгаа билээ. Төвийг сахисан бие даасан хараат бус хэмээх ойлголтонд бид ялгаатай байр суурь бүхий талуудыг сурвалжлах, ялгавартай хандахгүй бөгөөд сэтгүүлч хувийн үзэл бодлоо илэрхийлэхгүй зэрэг асуудлыг хамруулж байна”<sup>3</sup> гэж Шведийн радиогийн Хөгжлийн газрын Хамтын ажиллагааны төслийн зөвлөх мэргэжилтэн Матильда Дьорехед

онцлон тэмдэглэжээ. Ер нь МҮОНР-гийн шилжилтийн үед Шведийн радиогийн Медиа хөгжлийн Газрын хамтын ажиллагааны газраас хэрэгжүүлсэн төслүүд онцгой дэмжлэг үзүүлж, олон нийтийн радиогийн хамт олонд оруулсан оюуны бодитой хөрөнгө оруулалт болсон юм.

МҮОНР-гийн статусын өөрчлөлт нь харьцангуй амжилттай хийгдсэн ба олон улсын олон нийтийн радиогийн загварт нэлээд дөхсөн ололтуудыг бий болгож чадсан юм.

МҮОНР-гийн үйл ажиллагаанд олон улсад олон нийтийн радиогийн жишиг болсон зарчмууд хэрхэн тусгалаа олсныг авч үзье.

**Х**үртээмжтэй байх зарчим. Монголын үндэсний олон нийтийн радио нь нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтлахаар хуульчилсан бөгөөд үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Радио сонсох нь техникийн боломжоос шалтгаалдаг ба Радио телевизийн сүлжээний газар нь Улаанбаатар хотын Хонхор дахь радио нэвтрүүлэх төв станцаар, хөдөө орон нутагт Баян-Өлгий, Хөвсгөл, Говь-Алтай, Өмнөговь, Дорнод аймгуудын их хүчний станцаар, Улаанбаатар, Эрдэнэт хотод шугамын радио сүлжээгээр, бүх аймгийн төвүүдэд FM105.5 станцаар МҮОНР-гийн хөтөлбөрийг дахин дамжуулан хүргэж байна. Энэ нь нийт газар нутгийн 75 орчим хувьд нь радио долгионоор олон нийтийн өргөн нэвтрүүлэг хүрч байна. Радио сонсогчдын дийлэнх нь буюу 82 хувь нь орон нутгийн иргэд байдаг. Мэдээлэл дамжуулж буй хүрээ, тархалтын хувьд зохицуулалт дутагдалтай байгаа нь ажиглагддаг. Энэ талаар ихэнх төсөлд “Олон нийтийн

радио телевиз нь “нийт үндэсний эрх ашгийг хамгаална” гэсэн ерөнхий заалт орсон байх боловч, олон нийтийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах эрхийг газар нутгийн байршилтай холбож баталгаажуулах ямар нэг оролдлого гарсангүй<sup>4</sup> гэж МҮОНРТ-ийн инженер Ч.Цагаан тэмдэглэсэн байна.

Олон нийтийн радиогийн хүртээмжтэй байх зарчмын тухайд нарийн зохицуулалт өнөө хэр байхгүйгээс нийгмийн аль бүлэгт ямар хэмжээгээр нэвтрүүлэг зориулж хийх нь тодорхойгүй явж иржээ. Өнөөдрийн байдлаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэвтрүүлгүүд хийгдэж байгаа ч үндэсний цөөнхөд зориулсан нэвтрүүлэг огт байхгүй байна.

Хэвлэл мэдээллийн төвлөрөл хүчтэй явагдаж, эзэмшлийн асуудал нэн төвөгтэй байгаа энэ цаг үед манай улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд хараат бус байдал нэн эмзэг асуудал болж байна. МҮОНР-гийн хувьд хараат бус байдал харьцангуй сул байгааг судлаачид болон иргэний нийгмийн төлөөллүүд шүүмжилсээр ирсэн ч нөхцөл байдал өнөөдөр сайжраагүй хэвээр байна. Улс төрийн сонгууль бүрийн дараа сонгогдсон эрх баригчид төлөөний хүнээ удирдлагаар томилж, жил ирэх тутам сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод, ардчилсан зарчмын дагуу явагдахгүй, улс төрчид өөрсдийн гар хөл болох хүнээ томилсоор байна. Энэ бол МҮОНР-гийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болсоор байна. 2005 онд УИХ-аас ОНРТ-ийн тухай хуулийг баталж, төрийн мэдэлд байсан өргөн нэвтрүүлгийн байгууллагыг олон нийтийн болгон өөрчилж, нийгмийн бүх бүлэг давхаргын эрэлт хэрэгцээг хангах, улс

орны өнцөг булан бүрт хүрч үйлчлэх ба ардчилсан яриа хэлэлцүүлгийн талбар байхаар хуульчлав. Төрийн мэдэлд байсан монополь эрхтэй. Монголын Үндэсний өргөн нэвтрүүлгийн байгууллагыг олон нийтийн өргөн нэвтрүүлгийн болгон шилжүүлэх үедээ МҮОНРТ-ийн редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан. Гэсэн хэдий ч энэхүү шилжилт үр дүнгээ өгсөн эсэх, МҮОНРТ Засгийн газраас хараат бус байдаг эсэхэд эргэлзэх хүмүүс бий<sup>5</sup> гэж Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээнд цохон тэмдэглэсэн нь ч санамсаргүй хэрэг биш юм.

*Хараат бус байх зарчим.* МҮОНРТВ-ийн хараат бус байдал нэн эмзэг байгааг харуулсан үйл явдал бол 2008 оны 7 сарын нэгний өдөр олон нийтийг хамарсан үймээнийг сурвалжилсан үе байв. Энэ хугацаанд төрөөс МҮОНРТ-д хатуу цензур тогтоож, төрийн удирдлагад авсан бөгөөд Үндэсний Аюулгүй байдлын Шуурхай штабын шууд удирдлаган дор тус штабын мэдээллийг дамжуулж байсан. Энэ үеэр иргэний нийгмийн болон ард иргэдийн дуу хоолойг бүрмөсөн хязгаарлаж, телевиз, радиогоор нэвтэрч байсан нийт мэдээллийн 58.2% нь цагдаагийн байгууллага, төрийн албан хаагч зэрэг албаны эх сурвалжаас авсан мэдээлэл байв. ОНР-гийн хараат бус байдалд харш үйлдэл хийсэн бол хуулийн хариуцлага хүлээх ёстой ч өнөөдрийн байдлаар ийм хариуцлага тооцсон явдал гараагүй байна. МҮОНР-гийн хараат бус байдал өнөөдөр ч эмзэг хэвээрээ байна.

*Редакцийн хараат бус байдал.* МҮОНР нь редакцийн зохион байгуулалттай ба ерөнхий редактор нэвтрүүлгийн сэдвээ төлөвлөж, нэвтрүүлгийн бодлогоо тодорхойлдог. Гэхдээ зарим талаар радиогийн удирдлагууд

редакцийн дотоод асуудалд оролцох байдал ажиглагддаг. МҮОНР нь программын хэлтсийнхээ дэргэд Нэвтрүүлгийн зөвлөл хэмээх орон тооны ажилтнуудтай байсан ба редакторуудын бэлтгэсэн нэвтрүүлгийг сонсож, мэргэжил, ур чадварын шаардлагад хүрч хийж чадсан эсэх, сэдвийн сонголт зэрэг асуудлыг нягтлан хэлэлцдэг байсан нь байгууллагын дотоод цензур буюу цагдан хяналтын шинжтэй байснаараа редакцийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлдөг байсан. Энэ зөвлөлийг 2015 онд татан буулгаснаар редакцийн ерөнхий редакторууд нэвтрүүлгийн сэдвийн сонголт, нэвтрүүлгийн агуулга, чанар, ур чадварын асуудлыг хариуцах болсон нь дэвшилттэй алхам болж, редакцийн хараат бус байдалд дэвшил гарчээ.

**Р**едакцийн хараат бус байдлыг ОНРТВ-ийн тухай хуулиар баталгаажуулж өгсөн ба хөндлөнгөөс оролцохыг хориглосон байдаг ч энэ нь зарим тохиолдолд зөрчигддөг. Тухайлбал, ОНР-гийн удирдлагын түвшинд редакцийн хараат бус байдалд нөлөөлөх шийдвэр гаргах явдал түгээмэл ажиглагддаг. Ялангуяа эрэн сурвалжлах мэдээлэл бэлтгэх үед радиогийн удирдлагад гадны эх сурвалжууд нөлөөлөх, улмаар нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргах зэрэг үйлдэл гардаг нь редакцийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байна. Нөгөө талдаа редакцийн хараат бус байдлыг хангах болон редакторын эрхийг хамгаалах тал дээр учир дутагдалтай явж иржээ.

*Редакторын хараат бус байдал.* МҮОНР-гийн редакторууд нь харьцангуй бие даан ажиллаж, нэвтрүүлгийн сэдэв, агуулгыг сонгох эрхтэй байдаг ба ерөнхий редактор тэдэнтэй зөвшилцөх, редакцийг нэгд-

мэл удирдлагаар хангах байдлаар асуудалд ханддаг. Редакторын хараат бус байдлыг хангах талаар нарийвчилсан зохицуулалт хийгдээгүй, энэ ойлголт сонгодог утгаараа хөгжих суурь тавигдаагүй байна. МҮОНР-д ажиллаж буй сэтгүүлчдийн дийлэнх нь төр засгийн мэдэлд ажиллаж байх үеэс ажиллаж ирсэнтэй холбоотойгоор өөрийн буюу дотоод цензур байдаг тал бий. Доктор Ч.Базар “Монголын сэтгүүлчдийн дунд түгээмэл байдаг айдас болгоомжлол бол хамгийн харгис цензур мөн”<sup>6</sup> гэж тодорхойлсон нь үндэслэлгүй зүйл биш юм.

Редакторын хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь гэрээт буюу төлбөрт нэвтрүүлгийн асуудал юм. Аль нэг байгууллага, ямар нэг хувийн сонирхол үүгээр дамжиж илэрч, гэрээ хийсэн байгууллагын талаарх сөрөг мэдээллийг нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээх нь хаалтын гэрээний боловсон хувилбар юм.

**Х**увийн болон улс төрийн сонирхлоос ангид байх. МҮОНР-гийн хувьд хувийн сонирхол харьцангуй бага хэмжээнд нөлөөлдөг гэж үзэж болно. Гэхдээ нийт радио нэвтрүүлгийн агуулгын хувьд арилжааны сонирхол, далд сурталчилгаа байгаа эсэхийг нягталсан судалгаа өнөөдрийн байдлаар хийгдээгүй явж иржээ. 2010 онд Эдийн засаг, улс төрийн мэдээллийн бие даасан редакцитай байсныг “Хурд” агентлагт нэгтгэсэн нь улс төрийн сонирхлоос ангид байх дорвитой алхмын нэг болсон юм.

Энэ чиглэлд хийгдсэн эерэг зүйлүүд байгаа хэдий ч МҮОНР-гийн хувьд улс төрийн сонирхлоос хараат бус байх чадвар сул байна. Улс төрчид УИХ-ын сонгуулийн үеэр олон нийтэд нэр хүнд бүхий уран бүтээлч-дийг

өөрийн сурталчилгаанд ажил-луулж байгаа нь ч улс төрийн сонирхлоос хараат бус байхад сөргөөр нөлөөлж байна.

Улс төрийн хараат бус байдлыг хангах эрмэлзэл МҮОНР-гийн ажилтнуудын ёс зүйн, хувийн асуудлаа мэргэжлийн үйл ажиллагаатай хольж хутгахгүй байх зэрэг хувь хүний хөгжлийн асуудалтай ч холбогдоно. МҮОНР-гийн ажилтнууд нам бус байвал зохих ба энэ нь ёс зүйн хэм хэмжээг хэрхэн баримталдгаар илрэх учиртай. Улс төрийн сонирхлоос ангид байхыг эрмэлздэг байх нь нэн чухал юм.

*Эдийн засгийн хараат бус байдал.* ОНР-гийн гол онцлог нь санхүүжилт байдаг. Арилжааны болон далд сурталчилгааг хуулиар бүрэн хориглосон ба ОНР-оор нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн 2%-иас хэтрэхгүй байна гэж хуулиар хязгаарлалт тогтоож өгсөн. ОНР-гийн санхүүжилтийн хэлбэрүүд нь хуульд зааснаар МҮОНР-гийн санхүүжилт улсын төсвийн дэмжлэг, хураамжийн орлогоос голлон бүрдэж байна. МҮОНРТ-ийн нийт санхүүжилтийн 53.6%-ийг улсын төсвийн дэмжлэг, 26.4%-ийг нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс, 11.3%-ийг захиалгат нэвтрүүлгийн орлого, 8.7%-ийг түрээсийн болон төсөл, хөтөлбөрийн орлого эзэлж байна<sup>7</sup>. Ийнхүү улсын төсвийн дэмжлэг өндөр байгаа нь эдийн засгийн хараат бус байдал хангагдахгүй байх нэг үндэслэл болж байна. Нөгөөтэйгүүр ОНРТ-ийн хураамж нэмэгдэхгүй явж ирсэн ба хураамжийн орлого нэмэгдвэл хараат бус байдал сайжирна. Хураамжийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд олон нийтийн итгэлийг олсон байх нь чухал бөгөөд дэлхий нийтэд олон нийтийн



радиод итгэдэг олон нийт хураамжийг нэмэгдүүлэхийг дэмждэг сайн туршлага бий.

Төсөв хөрөнгө мөнгөний дутагдалтайгаас томилолтын зардал тэр болгон гаргаж чаддаггүй, сурвалж-лагч нараа гадны байгууллагын зардлаар гадагшаа болон дотоодод томилолтоор явуулдаг нь эдийн засгийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхийн сацуу нэвтрүүлгийн бодлогод гуравдагч этгээдийн сонирхол нөлөөлөл орж ирэх эрсдлийг бий болгож байна.

Эдийн засгийн хараат бус байдал нь МҮОНР-ийн ажилтны хувьд хангагдаж чадахгүй байна. Цалин багатайн улмаас давхар ажил эрхлэх, гадны этгээдээс эдийн засгийн хувьд хараат байх явдал гарсаар байна.

**И**йнхүү Монголын үндэсний радио “олон нийтийн” гэсэн статустай болсноос хойш 10 гаруй жил өнгөрч байна. Төрийн мэдлийн мэдээллийн хэрэгслээс олон нийтийн эрх ашигт үйлчилдэг болон өөрчлөгдөж, гагцхүү хуулиар байгуулагдаж, үйл ажиллагааг нь хуулийн хүрээнд, олон нийтийн радиогийн зарчимд үндэслэн ажиллах болсон нь МОНР үүсэн хөгжих таатай орчныг бүрдүүлсэн. ОНР Монголд байгуулагдсанаар хэвлэлийн эрх чөлөөг бататгах, Монголын сэтгүүл зүйн хөгжилд нэгэн шинэ хуудас нээгдэж, хэвлэл мэдээллийн салбарын төдийгүй ардчиллын нэгэн салшгүй хэсэг болон хөгжиж байна. Өнгөрсөн хугацаанд ОНР болон өөрчлөгдсөнөөр шинэ тутам асуудал сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байна.

#### Ишлэл

<sup>1</sup>Олон нийтийн радио телевизийн тухай хууль. УБ. 2005 3.1 дэх заалт

<sup>2</sup> Мөн тэнд, 4.1 дэх заалт.

- <sup>3</sup> Гүнсэн Л. “Хурд” хуучлах цагаар. УБ. 2010. х.98.
- <sup>4</sup> Цагаан Ч. Олон нийтийн телевизийн маркетингийн асуудал (Магистрын зэрэг горилсон бүтээл) УБ., 2006. х.15
- <sup>5</sup> Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016. УБ., х.12.
- <sup>6</sup> “Сэтгүүлч” сэтгүүл. УБ. 2004 №03(16), х.17.
- <sup>7</sup> МҮОНРТ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан. Үндэсний аудитын газар. УБ. 2013.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баярсайхан Б. “Олон нийтийн радиогийн хөтөлбөрийн бодлого, түүний онцлог” (Магистрын зэрэг горилсон бүтээл). УБ. 2010.
2. Гүнсэн Л. “Хурд” хуучлах цагаар. УБ. 2010.
3. Монголын радио түүхэн замналын товч хуанли. УБ. 1994.
4. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016.
5. МҮОНРТВ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан. Үндэсний аудитын газар. УБ. 2013.
6. Олон нийтийн радио телевизийн тухай хууль. УБ. 2005.
7. “Сэтгүүлч” сэтгүүл . УБ. 2004.
8. Цагаан ном. УБ. 2006.
9. Цагаан Ч. Олон нийтийн телевизийн маркетингийн асуудал (Магистрын зэрэг горилсон бүтээл). УБ. 2006.
10. Toby Mendel. Public service broadcasting: A comparative Legal Survey. France. 2011.
11. [www.mnb.mn](http://www.mnb.mn)
12. [www.unesco.org](http://www.unesco.org)

#### Abstract

Thirteen years have passed since Public Radio was founded in Mongolia in compliance with law. This public media with a special status has to adhere to internationally acknowledged principles in order to serve to public. As of now, impartiality of the public radio has still been vulnerable and principles to be free from private and political interests have not been completely applied yet.